



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нийцлийн аудитын тайлан

**Аймгийн Засаг даргын тамгын газрын 2016, 2017 оны үйл ажиллагаа,
Засаг даргын нөөц хөрөнгө, давсан орлогын зарцуулалт**

**ТУСЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНААС
ОРСОН ОРЛОГЫГ ТӨСВӨӨС
ГАДУУР ЗАРЦУУЛЖЭЭ.**

Баян-Өлгий аймаг, Өлгий сум

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:

**Баян-Өлгий аймаг дахь
Төрийн аудитын
газар**

Дарга, Тэргүүлэх аудитор
М.Хуанган

Аудитын менежер
Х.Женисбек

Аудитын баг
Аудитор
Б.Үүрийнтуяа

Аудитор
Ж.Назгүл

2018 оны 9 дүгээр сар

Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70423073 дугаарын утсаар хандана уу.

Хаяг: Аймгийн ЗДТГазрын байр 1-давхар

ХАЯГ: Аймгийн ЗДТГазрын байр, 1 дүгээр давхар 110, 112 тоот өрөө

Товчилсон үгийн тайлбар	3
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	4

Бүлэг 1 Аймгийн ЗДТГазрын үйл ажиллагааны төсвийг хууль журамд заасны дагуу төлөвлөж, зарцуулжээ.

- 1.1 *Тайлант онуудын үйл ажиллагааны батлагдсан төсөв үндэслэлтэй хийгдсэн байна.....*5-6
- 1.2 *Туслах үйл ажиллагааны орлогыг төсөвт төвлөрүүлэлгүй зарцуулж, батлагдсан төсвийг хэтрүүлж ажилласан байна.*7-9
- 1.3 *Байгууллагын үйл ажиллагааны бүтэц, орон тоо оновчтой зохион байгуулж ажиллуулсан байна.....*9-10
- 1.4 *Өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналтыг зохих журмын дагуу хэрэгжүүлсэн байна.....*11
- 1.5 *Төсвийн зарцуулалтад тавих дотоод хяналтын талаар.....*17

Бүлэг 2 Засаг даргын нөөц хөрөнгийг хууль, журмын дагуу бүрдүүлж, зарцуулсан байна.

- 2.1 *Засаг даргын нөөц хөрөнгийг төсвийн хууль тогтоомжийн дагуу төлөвлөж ажилласан байна.....*12
- 2.2 *Засаг даргын нөөц хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж тайлагнасан байна.....*12-14

Бүлэг 3 Давсан орлогыг хууль, журмын дагуу бүрдүүлж, зарцуулсан байна.

- 3.1 *Давсан орлогыг төсвийн хууль тогтоомжийн дагуу төлөвлөж, хуваарилсан байна.....*15-16
- 3.2 *Давсан орлогыг төсвийн хууль тогтоомжийн дагуу зарцуулж, тайлагнасан байна.....*16
- 3.3 *Худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулсан байна.*17

<i>Дүгнэлт.....</i>	18
<i>Зөвлөмж.....</i>	19
<i>Байгууллагын санал.....</i>	20
<i>Баталгаажуулсан гарын үсэг.....</i>	21

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Аудитын зорилт:

Монгол Улсын Ерөнхий аудитор 2018 онд нийлүүлэх ажил үйлчилгээний төлөвлөгөө, аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны аудитын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу аймгийн Засаг даргын тамгын газрын 2016, 2017 оны үйл ажиллагаа, Засаг даргын нөөц хөрөнгө, давсан орлогын зарцуулалтад нийцлийн аудит хийж үр дүнг холбогдох байгууллагад танилцуулах, үйл ажиллагааны үр дүнг сайжруулах талаар холбогдох байгууллага, албан тушаалтнуудад санал, зөвлөмж өгөх, үр дүнг олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэв.

Хамрах хүрээ:

Энэхүү аудитад аймгийн Засаг даргын тамгын газар, Засаг даргын нөөц хөрөнгө, давсан орлогын 2016, 2017 оны үйл ажиллагаатай холбоотой санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан, санхүүгийн баримт материал, ажлын төлөвлөгөө, тооцоо судалгаа бусад холбогдох баримтуудыг хамруулав.

Эрсдэлийн үнэлгээ:

Аудитын төлөвлөлтийн явцад судалсан баримт материалд үндэслэн хийсэн урьдчилсан дүн шинжилгээнд үндэслэн ерөнхий эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, ажлын тайлан, баримт материалд дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг ашигласны зэрэгцээ аудитын хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Аудитын багийн бүрэлдэхүүн:

Аудитыг аудитор Б.Үүрийнтуяа ахалж, аудитор Ж.Назгүл нарын бүрэлдэхүүнтэй аудитын баг 2018 оны 05 дугаар сарын 21-ээс эхлэн 08 дугаар сарын 30-ны хооронд хийж гүйцэтгэв.

Бүлэг 1

Үйл ажиллагааны урсгал зардлын төсөв үндэслэлтэй хийгдсэн байна.

Оршил

Аймгийн Засаг даргын тамгын газар нь “Төр засгийн болон аймгийн бодлогын хэрэгжилтийг шуурхай удирдлагаар хангах, үр дүнг шударгаар тооцох замаар төрийн үйлчилгээний бүтээмжийг нэмэгдүүлэх, иргэддээ чанартай үйлчилгээ үзүүлэх, улмаар орон нутгийн хөгжлийг тэтгэх чадварлаг захиргааны байгууллагыг төлөвшүүлэх” эрхэм зорилгын дор үйл ажиллагаагаа явуулсан байна.

Аймгийн Засаг даргын тамгын газар нь 2016 онд 1609.6 сая төгрөгийн, 2017 онд 1676.8 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаагаа явуулжээ.

Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнд 2016 онд 456.6 сая төгрөгийн, 2017 онд 313.8 сая төгрөгийн, давсан орлогод 2016 онд 180.9, 2017 онд 191.4 сая төгрөгийн төсөв тус тус батлагдсан байна.

1. Аймгийн ЗДТГазрын үйл ажиллагааны төсвийг хууль журамд заасны дагуу төлөвлөж, зарцуулжээ.

1.1. Үйл ажиллагааны урсгал зардлын төсөв үндэслэлтэй хийгдсэн байна.

Аймгийн ИТХ-ын 2016 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 08 тоот тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан тодотголд аймгийн Засаг даргын тамгын газрын 2016 оны төсвийн зарлагыг 1609.1 сая төгрөгөөр баталжээ.

Аймгийн ИТХ-ын 2017 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 16 тоот тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан тодотголд аймгийн Засаг даргын тамгын газрын 2017 оны төсвийн зарлагыг 1676.7 сая төгрөгөөр тодотгож баталсан байна.

Аймгийн Засаг даргын тамгын газар нь аймгийн ИТХ-аас батлагдсан төсвийг Төсвийн тухай хуулийн дагуу зориулалтаар нь зарцуулах бодлого баримталж ажилласан байна.

Батлагдсан төсвийг өмнөх онуудтай харьцуулсан судалгаа

Хүснэгт №1

Үзүүлэлт	2015 он	2016 он	2017 он	/сая төгрөг/	
				Зөрүү	
				2015 онтой харьцуулахад	2016 онтой харьцуулахад
	а	б	с	б-а	с-б
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,257.5	1,609.6	1,676.7	352.10	67.10
УРСГАЛ ЗАРДАЛ	1,257.5	1,609.6	1,676.7	352.10	67.10
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,174.6	1,501.9	1,636.3	327.30	134.40
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	614.8	590.7	605.2	(24.10)	14.50
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	67.6	64.9	68.0	(2.70)	3.10
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	174.2	164.8	162.4	(9.40)	(2.40)
Хангамж, бараа материалын зардал	87.7	67.9	74.2	(19.80)	6.30
Нормативт зардал	2.5	3.3	3.3	0.80	-
Эд хогшил, урсгал засварын зардал	19.2	8.1	31.7	(11.10)	23.60
Томилолт, зочны зардал	53.6	31.1	46.3	(22.50)	15.20
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	113.4	4.3	1.9	(109.10)	(2.40)
Бараа үйлчилгээний бусад зардал	41.5	566.8	643.2	525.30	76.40
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	82.8	107.6	40.5	24.80	(67.10)
Засгийн газрын урсгал шилжүүлэг	63.8	61.4		(2.40)	(61.40)
Бусад урсгал шилжүүлэг	19.0	46.2	40.5	27.20	(5.70)
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,257.5	1,609.6	1,676.8	352.10	67.20
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,257.5	1,609.6	1,676.8	352.10	67.20
Орон нутгийн төсвөөс	1,257.5	1,609.6	1,676.8	352.10	67.20

/Эх сурвалж: Аймгийн ЗДТГ-ын тайлангаас/

2016 оны батлагдсан төсвийг өмнөх оноос 352.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталсан байна. Энэ нь орон нутгийн давсан хэсэг болон Засаг даргын нөөц хөрөнгийн зардлыг Засаг даргын тамгын газрын батлагдсан төсөвтэй хамт суулгаж өгсөнтэй холбоотой байна.

2016 оны батлагдсан төсвийг 2015 оны төсөвтэй харьцуулахад: цалингийн зардлыг 24.1 сая төгрөгөөр, НДШ-ийн зардлыг 2.7 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 9.4 сая төгрөгөөр, хангамж бараа, материалын зардлыг 19.8 сая төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 11.1 сая төгрөгөөр, томилолт, зочны зардлыг 22.5 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 109.1 сая төгрөгөөр, засгийн газрын урсгал шилжүүлгийг 2.4 сая төгрөгөөр бууруулж, бараа, ажил үйлчилгээний бусад зардлыг 525.3 сая төгрөгөөр, бусад урсгал шилжүүлгийг 27.2 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталсан байна.

2017 оны батлагдсан төсвийг 2016 оноос 67.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталжээ.

2017 оны төсвийг 2016 оны төсөвтэй харьцуулахад: байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 2.4 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 2.4 сая төгрөгөөр, засгийн газрын урсгал шилжүүлгийг 61.4 сая төгрөгөөр, бусад урсгал шилжүүлгийг 5.7 сая төгрөгөөр бууруулж, цалингийн зардлыг 14.5 сая төгрөгөөр, НДШ-ийн зардлыг 3.1 сая төгрөгөөр, хангамж бараа, материалын зардлыг 6.3 сая төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 23.6 сая төгрөгөөр, томилолт, зочны зардлыг 15.2 сая төгрөгөөр, бараа, ажил үйлчилгээний бусад зардлыг 76.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталжээ.

1.2. Туслах үйл ажиллагаанаас орсон орлогыг төсвөөс гадуур зарцуулжээ.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсэгт “Төсвийн шууд захирагч төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 16.5 дахь хэсгийн 16.5.2 дахь заалтад “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад хяналт тавих”, 16.5.5 дахь заалтад “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсгийн 41.2.2-т “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах” гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажилласан байна.

Урсгал зардалд 2016 онд 1609.6 сая төгрөгийн, 2017 онд 1668.6 сая төгрөгийн санхүүжилт авч үйл ажиллагаандаа зарцуулжээ.

2016, 2017 оны төсвийн гүйцэтгэлийн судалгаа Хүснэгт №2
/сая төгрөг/

Үзүүлэлт	2016 он	2017 он	Зөрүү
	Гүйцэтгэл	Гүйцэтгэл	
	a	b	b-a
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,584.2	1,668.6	84.40
УРСГАЛ ЗАРДАЛ	1,584.2	1,668.6	84.40
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,475.4	1,628.1	152.70
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	590.6	605.2	14.60
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	64.9	68.0	3.10
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	163.1	162.4	(0.70)
Хангамж, бараа материалын зардал	70.3	74.2	3.90
Нормативт зардал	3.5	3.3	(0.20)
Эд хогшил, урсгал засварын зардал	8.6	31.7	23.10
Томилолт, зочны зардал	33.4	46.3	12.90
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2.1	1.8	(0.30)
Бараа үйлчилгээний бусад зардал	538.9	635.0	96.10
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	108.8	40.5	(68.30)
Засгийн газрын урсгал шилжүүлэг	61.4	-	(61.40)
Бусад урсгал шилжүүлэг	47.4	40.5	(6.90)
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,584.1	1,668.6	84.50
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,584.1	1,668.6	84.50
Орон нутгийн төсвөөс	1,584.1	1,668.6	84.50

/Эх сурвалж: Аймгийн ЗДТГ-ын тайлангаас/

2017 оны гүйцэтгэлийг 2016 оны гүйцэтгэлтэй харьцуулахад: цалин, НДШ-ийн зардал, хангамж бараа материалын зардал, эд хогшил, урсгал засварын зардал, томилолт, зочны зардал, бараа, ажил үйлчилгээний бусад зардлуудын гүйцэтгэл өмнөх оноос 3.1-96.1 сая төгрөгөөр нэмэгдэж, бусад зардлууд 0.20-68.3 сая төгрөгөөр буурч төсвийн зарцуулалт өмнөх оноос 84.4 сая төгрөгөөр өссөн байна.

Төсвийн гүйцэтгэлийн судалгаа Хүснэгт №3

/сая төгрөг/

Онууд	Батлагсан төсөв	Гүйцэтгэл	Хэмнэлт, хэтрэлт
2016 он	1609.6	1584,2	-25,4
2017 он	1676.8	1668.6	-8.2

/Эх сурвалж: Аймгийн ЗДТГ-ын тайлангаас/

Батлагдсан төсвийг 2016 онд 25.4 сая төгрөгөөр, 2017 онд 8.2 сая төгрөгөөр хэмнэж, төсөвт төвлөрүүлсэн байна.

Аймгийн Засаг даргын тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансанд 2016 онд Засгийн газраас олгосон гамшгийн сангийн хөрөнгөнд 80.0 сая төгрөгийн, Онцгой байдлын газраас томилолтын зардлын санхүүжилтэд 5.7 сая төгрөгийн, шатахууны зардалд 0.6 сая төгрөгийн, Архивын газрын ажилчдын цалин, НДШимтгэлийн зардалд 21.0 сая төгрөгийн, цэргийн дүйцүүлэх албаны зардалд 6.7 сая төгрөгийн, цэргийн штабын сургалт, дайчилгааны зардалд 8.7 сая төгрөгийн, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс хуваарилсан наадмын зардалд 15.0 сая төгрөгийн, Казахстан улсаас үерийн гамшигт ирсэн тусламжид 418.9 сая төгрөгийн, Хүний эрхийн үндэсний комиссоос түрээсийн зардалд 0.4 сая төгрөгийн, архивын орлогоос 2.0 сая төгрөгийн нийтдээ 559.0 сая төгрөгийн санхүүжилт орсон байна.

Архивын орлогоос орсон 2.0 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлэхгүйгээр зарцуулж Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2-д “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах” 47 дугаар зүйлийн 47.3-т “энэ хуулийн 47.1.5-д заасан орлогыг зөвхөн батлагдсан төсвийн хүрээнд зарцуулна”, Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журмын 2.6-д “Төсвийн байгууллага үндсэн болон туслах үйл ажиллагаанаас орох орлогыг мөнгөн касстаа бэлнээр хүлээн авч энэхүү орлогыг /түүнийг шууд захиран зарцуулах эрхгүй/ ажлын дараагийн өдөрт багтаан кассын нярав Төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана” гэсэн заалтуудыг зөрчсөн байна. Аудитын дүнгээр энэхүү зөрчлийг арилгаж, цаашид давтан гаргахгүй байх талаар албан шаардлага өгөв.

2017 онд нэмэлт санхүүжилтийн дансанд БХЯамнаас цэргийн дүйцүүлэх албанд 9.7 сая төгрөгийн, Хууль зүйн дотоод хэргийн яамнаас сургалтын зардалд 12,0 сая төгрөгийн, тогтвортой бичил уурхай төслөөс 8.3 сая төгрөгийн, Засгийн газрын нөөц сангаас мал хамгаалах санд 25.0 сая төгрөгийн, УИХ-ын тамгын хэлтсээс томилолтын зардалд 6.6 сая төгрөгийн, Архивын ерөнхий газрын гэрээт ажилтны цалинд 15.1 сая төгрөгийн, архивын орлогоос 4.3 сая төгрөгийн буюу нийтдээ 81.0 сая төгрөгийн санхүүжилт орсныг зориулалтын дагуу зарцуулжээ.

Архивын орлогоос орсон 4.3 сая төгрөгийг оны эцэст орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1-д “Төсвийн байгууллага дараах шаардлагыг хангасан тохиолдолд туслах үйл ажиллагаа явуулж, орлого олж болно”, 44.1.3-д “санхүүгийн тайлан болон үр дүнгийн гэрээнд уг үйл ажиллагааны талаар зохих ёсоор тусгасан байх” гэсэн заалтыг зөрчсөний зэрэгцээ аймгийн ЗДТГ-ын төсөвт үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого

төлөвлөгдөөгүй боловч зочид буудал, гуанзны орлогоос 2016-2017 онд 2.5 сая төгрөгийн орлого оруулж, зарцуулсан байна.

Аймгийн ЗДТГ-ын дарга иргэн Е.Манаргүлтэй түрээсийн гэрээ байгуулж, ЗДТГ-ын гуанзны өрөөг сарын 50.0 мянган төгрөгөөр, жилийн 0.6 сая төгрөгөөр түрээслүүлж, гэрээнд түрээсийн мөнгийг нэмэлт санхүүжилтийн 020051407 тоот дансанд оруулж байхаар тусгажээ.

Гэрээ байгуулснаас хойш эхний 7 сарын түрээсийн төлбөрт 0.3 сая төгрөгийг хүлээн авч ЗДТГ-ын аж ахуйн үйл ажиллагаанд зарцуулсан боловч касст орлого аваагүй, анхан шатны бүрдэл дутуу баримтаар зарцуулсан байна.

Засаг даргын тамгын газрын зочид буудлыг аж ахуйн аргаар ажиллуулж, 2016-2017 онд 2.1 сая төгрөгийн орлого оруулсан боловч касст орлого авч тайлагнаагүй, анхан шатны баримт, зарцуулалтын тайлан гаргаагүй, буудалд худалдаж авсан үндсэн хөрөнгийг орлогод авч бүртгэлд тусгаагүй, буудлын үйлчлүүлэгчийн бүртгэл хөтлөөгүй байна.

2016 оноос хойш шинээр ажилд орсон төрийн захиргааны албан хаагчдын төрийн албанд ажилласан жилээр цалингийн шатлал, нэмэгдэл цалинг тогтоосон байдлыг шалгаж үзэхэд Хүний нөөцийн бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн, Хөдөлмөр, нийгмийн хамгаалал, гэр бүл хүүхэд залуучууд, жендерийн төсөл хөтөлбөр хариуцсан мэргэжилтнүүдийн төрийн алба хаасан хугацааг улсад нийт ажилласан жилээр бодож цалингийн шатлалыг ахиулж 1.0 сая төгрөгийн цалинг илүү олгосон байна.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-т “санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах”, 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах; 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсгийн 41.2.2-д “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах” 47.3-т “энэ хуулийн 47.1.5-д заасан орлогыг зөвхөн батлагдсан төсвийн хүрээнд зарцуулна”,

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13-р зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна",

Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журмын 2.6-д “Төсвийн байгууллага үндсэн болон туслах үйл ажиллагаанаас орох орлогыг мөнгөн кастаа бэлнээр хүлээн авч энэхүү орлогыг /түүнийг шууд захиран зарцуулах эрхгүй/ ажлын дараагийн өдөрт багтаан кассын нярав Төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана”,

Засгийн газрын 1995 оны 96 дугаар тогтоол, 2014 оны 332 дугаар тогтоол, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн тайлан гаргах заавар аргачлал”-ын холбогдох заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Аудитын дүнгээр дээрх зөрчлүүдийг арилгаж, цаашид давтан гаргахгүй байх талаар албан шаардлага өгөв.

1.3. Байгууллагын үйл ажиллагааны бүтэц, орон тоог оновчтой зохион байгуулж ажиллуулсан байна.

Монгол Улсын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2 дахь хэсэгт “Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг Засгийн газраас тогтоох бөгөөд аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар нь хэлтэс, тасагтай байна”, 33 дугаар зүйлийн 33.4-т “Аймаг, нийслэл, сум, дүүргийн Тамгын газрын дарга тухайн шатны Засаг даргатай зөвшилцөн Засгийн газраас тогтоосон бүтэц, орон тооны хязгаарт багтаан Тамгын газрын орон тоо, цалингийн санг тогтоож, ажилтнуудыг томилж, чөлөөлнө” гэснийг хэрэгжүүлж ажилласан байна.

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны “Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтцийг шинэчлэн тогтоох тухай” 9 дүгээр тогтоолын:

Аймгийн удирдлагыг Засаг дарга, Засаг даргын орлогч, Засаг даргын Тамгын газрын дарга байхаар, аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтцийг:

- Төрийн захиргааны удирдлагын хэлтэс;
- Хууль, эрх зүйн хэлтэс (архивын тасагтай);
- Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс;
- Нийгмийн бодлогын хэлтэс;
- Санхүү, төрийн сангийн хэлтэс;
- Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс;
- Цэргийн штаб гэсэн бүтэцтэй байхаар тогтоосныг баримталж ажилласан байна.

3-т Орон нутгийн онцлог, нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын тоо, эдийн засаг, үйлдвэрлэлийн цар хүрээнээс хамааруулан Баян-Өлгий, аймгийн Засаг даргын Тамгын газрыг 41 хүртэл орон тоотой байхаар тогтоосон байна.

Сангийн яамнаас Аймгийн ЗДТГ-ын орон тооны хязгаарыг 67 орон тоогоор хянаж ирүүлжээ.

Аймгийн ЗДТГ-ын даргын 2017 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн “Аймгийн ЗДТГ-ын бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай” 30 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар Засаг даргын тамгын газрын шинэчилсэн орон тоог 41, 2 дугаар хавсралтаар нийтлэг үйлчилгээний албаны орон тоог 31 бүгд 72 орон тоогоор баталсан байна.

Батлагдсан орон тооны гүйцэтгэл

Хүснэгт №4

Бүтэц	2017 он	
	Батлагдсан орон тоо	Гүйцэтгэлээр
Аймгийн удирдлага	4	4
Төрийн захиргааны удирдлагын хэлтэс	6	6
Хууль эрх зүйн хэлтэс/Архивын тасагтай/	6	6
Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс	5	5
Нийгмийн бодлогын хэлтэс	5	4
Санхүү, төрийн сангийн хэлтэс	9	9
Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс	3	3
Цэргийн штаб	3	3
Нийтлэг үйлчилгээний алба	31	28
Дүн	72	68

/Эх сурвалж: Аймгийн ЗДТГ-ын тайлангаас/

Аймгийн Засаг дарга нь Нийгмийн бодлого болон дэд бүтэц хариуцсан 2 орлогчтой байхаар баталж, ажиллуулсан байна.

ЗДТГазар нь орон тоог Сангийн яамнаас хянаж ирүүлсэн орон тооны хязгаар, цалингийн сандаа багтааж ажиллуулсан байна.

1.4. Дотоодын хяналтыг зохих журмын дагуу хэрэгжүүлсэн байна.

Аймгийн ЗДТГазар нь 2016 онд 63.8 сая төгрөгийн, 2017 онд 78.5 сая төгрөгийн бараа материалыг төсвийн хөрөнгөөр худалдан авч зохих журмын дагуу зарцуулсан байна.

Шатахууныг “НИК” ХХК-аас гэрээгээр худалдан авч, үйл ажиллагаанд шаардлагатай, хангамжийн материал, түүхий эд, сэлбэг хэрэгсэл болон бусад бараа материалыг гэрээгээр болон шууд худалдан авалтаар бэлтгэсэн байна.

2016 онд 7.2 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга хэрэгслийг төсвийн хөрөнгөөр худалдан авч, 49.3 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүй авч, 32,6 сая төгрөгийн тээврийн хэрэгслийг шилжүүлжээ.

2017 онд төсвийн хөрөнгөөр 11.3 сая төгрөгийн хөрөнгө, аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 47,9 сая төгрөгийн барилгын их засвар, 43.7 сая төгрөгийн авто тээвэр, 2,3 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 17.7 сая төгрөгийн тавилга эд хогшил, бүгд 111.6 сая төгрөгийн хөрөнгийг хүлээн авчээ.

Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2017 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 135 дугаар тогтоолоор 121 нэр төрлийн 36.7 сая төгрөгийн тавилга эд хогшил, 57 нэр төрлийн 92.8 сая төгрөгийн тоног төхөөрөмж, бүгд 129.5 сая төгрөгийн ашиглалтын хугацаа дууссан хөрөнгийг акталсан байна.

Үндсэн хөрөнгө, бараа материалыг зөв ангилан бүртгэж, үндсэн хөрөнгийн элэгдлийг зохих журмын дагуу тооцож байгуулсан байна.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу 2017 оны 8 сараас Хяналт шинжилгээ үнэлгээний дотоод аудитын нэгж байгуулагдсан боловч тайлант онд ЗДТГазрын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгээгүй байна.

Аудитын дүнгээр архивын үйл ажиллагаанаас орсон орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлж, зочид буудал, гуанзны түрээсийн орлогыг сар бүр тооцоо хийж оруулж байх, төсвөөс гадуур зарцуулалт хийхгүй байх талаар нийт 5.4 сая төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлага өгч, 2017 оны түрээсийн төлбөрийн дутуу 0.4 сая төгрөгийг нөхөн төлүүлэхээр акт тогтоов.

Бүлэг 2

Засаг даргын нөөц хөрөнгийг хууль, журмын дагуу бүрдүүлж, зарцуулсан байна.

1. Засаг даргын нөөц хөрөнгийг хууль, журмын дагуу бүрдүүлж, зарцуулсан байна.

1.1. Засаг даргын нөөц хөрөнгийг төсвийн хууль тогтоомжийн дагуу төлөвлөж ажилласан байна.

Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгө 2015 оноос өмнө тусдаа данстай байсан ба 2016 оноос аймгийн ЗДТГ-ын бараа ажил үйлчилгээний бусад зардал дансаар төлөвлөж, зарцуулж ирсэн байна

Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнахад Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ыг баримталсан байна.

Энэхүү журмын 2.2-т “Засаг даргын нөөц хөрөнгийг орон нутгийн төсөвт нийт дүнгээр тусган тухайн шатны Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар батлуулна” гэсний дагуу аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийг аймгийн ЗДТГ-ын төсөвтэй хамт батлуулан ажиллажээ.

Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнд 2016 онд 456.6 сая төгрөгийн, 2017 онд 313.8 сая төгрөгийн хөрөнгийг орон нутгийн орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Засаг даргын нөөц хөрөнгийн 2016 оны эхний улирлын 85.0 сая төгрөгийн санхүүжилт 020051000 тоот дансаар дамжин зарцуулагдсан байна.

Журмын 2.3-т “Энэ журмын 2.1.1, 2.1.2 дахь хэсэгт заасан хохирлыг арилгахтай холбогдсон арга хэмжээг санхүүжүүлэхэд зориулж нийт батлагдсан хөрөнгийн 30-аас доошгүй хувийг Засаг даргын нөөцөд байлгана” гэж заасны дагуу сар бүр байх нөөцийн үлдэгдлийг хангаж ажилласан байна.

1.2. Засаг даргын нөөц хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж, тайлагнасан байна.

“Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 3.1-д “Засаг даргын нөөц хөрөнгийг Засаг даргын зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн тухайн шатны Засаг даргын захирамжаар зарцуулна” гэсний дагуу зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэж аймгийн Засаг даргын захирамжаар зарцуулсан байна.

Журмын 3.2-т “Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулах шийдвэр нь тухайн жилийн орон нутгийн төсөвт батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн нийт хэмжээнээс хэтрэхгүй байна” гэсний дагуу батлагдсан хэмжээнд багтаан зарцуулсан байна.

Журмын 3.3-т “Энэ журмын 2.1.1, 2.1.2 дахь хэсэгт заасан хохирлыг арилгахтай холбогдсон арга хэмжээний санхүүжилтийг эхний ээлжинд Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргана” гэсний дагуу зарцуулсан эсэхийг шалгахад:

Журмын 3.4-т “Энэ журмын 2.1.1, 2.1.2 дахь хэсэгт заасан хохирлыг арилгахтай холбогдон Засгийн газрын нөөц сангаас нэмэлт хөрөнгө гаргах зайлшгүй шаардлагатай бол тухайн шатны Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргасан зардлын тайлан, тооцоо, тайлбар, танилцуулгыг нэмж шаардагдах зардлын саналын хамт Онцгой байдлын ерөнхий газарт ирүүлнэ” гэсний дагуу Засгийн газрын нөөц хөрөнгөөс аймгийн ЗДТГ-т 2016 онд 80.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгож, аймгийн өвөлжилт, хаваржилтын хүндрэлийг даван туулахад зориулан аймгийн Онцгой комиссын хурлын шийдвэрийн дагуу зарцуулсан байна.

2017 онд 25.0 сая төгрөгийн санхүүжилтийг Засаг даргын 666 тоот захирамжаар мал хамгаалах санд төвлөрүүлжээ.

Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөд 2016 онд 456.6 сая төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 442.4 сая төгрөгийг зарцуулж, 14.2 сая төгрөгөөр хэмнэж, хэмнэлтийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

2017 онд 313.8 сая төгрөгийн батлагдсан төсвөөр ажиллаж, гүйцэтгэлээр 313.7 сая төгрөг зарцуулж, 0.1 сая төгрөгөөр хэмнэснийг буцаан төвлөрүүлсэн байна.

Засаг даргын нөөц хөрөнгийн төсвийн гүйцэтгэл

Хүснэгт №4
/сая төгрөг/

Онууд	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Зөрүү
2016 он	456,6	442,4	14,2
2017 он	313,8	313,7	0,1

/Эх сурвалж: Аймгийн ЗДТГ-ын тайлангаас/

Засаг даргын нөөц хөрөнгийн 2016 оны төсвийн нийт зардлын 75.2 хувийг буюу 332.7 сая төгрөгийг урьдчилан тооцох боломжгүй цаг үеийн шинжтэй зарим арга хэмжээний зардалд зарцуулжээ.

Бараа ажил үйлчилгээний урсгал зардалд 292.3 сая төгрөг, гадаад, дотоодоос ирсэн зочин төлөөлөгчийг хүлээж авахад 29.5 сая төгрөг, олон улсын болон улс орон нутгийн чанартай уралдаан тэмцээний зардалд 10.9 сая төгрөг, шагнал урамшуулалд 0.8 сая төгрөг тус тус зарцуулсан байна.

Үүнээс гадна 11.1 хувийг буюу 49.1 сая төгрөгийг байгалийн гамшиг, ослын үр дагаврыг арилгах болон байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх зардалд, 11.2 хувийг буюу 49.4 сая төгрөгийг Цагаан сар, Наурыз, Бүргэдийн баяр, Монгол цэргийн баяр, Улсын баяр, Шинэ жилийн арга хэмжээний зардалд, 0.9 хувийг

буюу 4.2 сая төгрөгийг 2017 оны цэргийн шинэчилсэн тоо бүртгэл, цэргийн цугларалт, сургалт, цэрэг татлагын зардалд, 1.6 хувийг буюу 7.0 сая төгрөгийг аймгийн мал тооллогын зардалд тус тус зарцуулжээ.

292.3 сая төгрөгийн бараа ажил үйлчилгээний зардал дотор аймгийн ИТХ-ын тогтоолоор батлагдсан 100.9 сая төгрөгийн давсан орлогын зарцуулалт хамт тайлагнагджээ.

Төсвийн хэлбэлзэлийн тайлангийн 81102 тоот Орон нутгийн нөөц хөрөнгө ангилал дотор байгаа 210901 тоот бараа ажил үйлчилгээний бусад зардлын код, 81104 тоот Бусад ангилагдаагүй нөөц хөрөнгө ангилал дотор байгаа 210901 тоот бараа ажил үйлчилгээний зардлын код адил байсныг ташаарч гүйлгээ хийхдээ хооронд нь гүйлгэн зарцуулж байсантай холбоотой байна. Энэ нь бодит гүйцэтгэлийг гаргахад хүндрэлтэй байсан болно.

2017 онд Засаг даргын нөөц хөрөнгийн 48.1 хувийг буюу 151.0 сая төгрөгийг урьдчилан тооцох боломжгүй цаг үеийн шинжтэй зарим арга хэмжээний зардалд зарцуулсан байна. Үүнээс 16.0 сая төгрөгийг шагнал урамшуулалд, 34.7 сая төгрөгийг гадаад, дотоодоос ирсэн зочин төлөөлөгчийг хүлээж авах зардалд, 23.7 сая төгрөгийг олон улсын болон улс орон нутгийн чанартай уралдаан тэмцээний зардалд, 76.6 сая төгрөгийг бусад арга хэмжээний зардалд зарцуулжээ.

Мөн 25.8 хувийг буюу 81.0 сая төгрөгийг байгалийн гамшиг, ослын үр дагаврыг арилгах болон байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх зардалд, 20.5 хувийг буюу 64.4 сая төгрөгийг Цагаан сар, Наурыз, Бүргэдийн баяр, Монгол цэргийн баяр, Улсын баяр, Шинэ жилийн арга хэмжээний зардалд, 5 хувийг буюу 15.8 сая төгрөгийг цэргийн шинэчилсэн тоо бүртгэл, цэргийн цугларалт, сургалт, цэрэг татлагын зардалд, 0.5 хувийг буюу 1.5 сая төгрөгийг мал тооллогын зардалд тус тус зарцуулжээ.

2015 онд Засаг даргын А/350 тоот захирамжаар 2014 оны төсвийн үлдэгдлээс 69.0 сая төгрөгийг хос хэлээр сургалт явуулдаг сургуулиудын монгол хэлний сурах бичгийн зардлыг санхүүжүүлэх шийдвэр гаргасан боловч тухай жилийн төсвийн үлдэгдэл хүрэлцээгүйн улмаас 2016 онд 2015 оны төсвийн үлдэгдлээс 41.6 сая төгрөгийг Засаг даргын А/44 тоот захирамжаар эргэн төлөгдөх нөхцөлөөр Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахаар шийдвэрлэснээс тухайн онд 25.0 сая төгрөгийг олгосон байна.

Дээрх мөнгө 2016 оны төсвийн үлдэгдлээс шийдвэрлэгдэх байсан боловч эргэж төлөгдөөгүй байна.

Засаг даргын нөөц хөрөнгийг Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.1, 2.1.2, 2.1.3-т заалтуудыг мөрдөж ажилласан байна.

Аймгийн аудитын газраас 2015 онд Засаг даргын нөөц хөрөнгийн 2014 оны зарцуулалтад хийсэн гүйцэтгэлийн аудитаар бүрдэл дутуу баримтаар болон зориулалт бус зарцуулсан 281.8 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах албан шаардлага өгч байсан ба энэхүү зөрчлүүдийг арилгаж 2016, 2017 онуудад нөөц хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Бүлэг 3

Давсан орлогыг төсвийн хууль тогтоомжийн дагуу төлөвлөж, хуваарилсан байна.

2. Давсан орлогыг хууль, журмын дагуу бүрдүүлж, зарцуулсан байна.

2.1. Давсан орлогыг төсвийн хууль тогтоомжийн дагуу төлөвлөж, хуваарилсан байна.

Төсвийн тухай хуулийн 57.3-т “Орон нутгийн төсвийн урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэх зарлагыг төсөвт тусган баталж хэрэгжүүлэх ба зарлага нь санхүүжүүлэх эх үүсвэрээсээ хэтрэхгүй байна” гэсний дагуу аймгийн ИТХ-ын хуралдаанаас аймгийн орон нутгийн давсан орлогыг зарцуулах арга хэмжээний төлөвлөгөөнд аймгийн ЗДТГ-аас зарцуулах арга хэмжээнүүдийг оруулж баталсан байна.

Аймгийн ИТХ-ын хуралдааны 2016 оны 68 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Аймгийн 2015 оны орон нутгийн төсвийн үлдэгдлээс санхүүжүүлэх урсгал зардал”-ын жагсаалтад аймгийн ЗДТГ-ын бараа ажил үйлчилгээний зардалд нийтдээ 281.7 сая төгрөгийн төсөв баталж, дараах арга хэмжээнүүдэд зарцуулахаар төлөвлөсөн байна. Үүнд:

- 7 хүний эмчилгээний зардалд 48.5 сая төгрөг,
- Аймгийн чөлөөт ахмадын холбоонд санхүүгийн дэмжлэгт 5.0 сая төгрөг, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих орон нутгийн оролцооны дэмжлэг 15.0 сая төгрөг, Иргэний зөвлөлийн дэмжлэгт 3.0 сая төгрөг, нийтдээ 23.0 сая төгрөг,
- Нийгмийн халамж үйлчилгээний хэлтэс, Статистикийн хэлтсийн гэрээт ажилтны цалин хөлст 26.0 сая төгрөг, Жана өлке ОНӨАТҮГазрын ажилчдын цалинд 5.0 сая төгрөг, Татварын хэлтсийн орон тооны бус байцаагч нарын цалинд 8.7 сая төгрөг, бүгд 39.7 сая төгрөг,
- Шүүхийн шийдвэрээр Көшелик ХХК, Монрос- Алтай ХХК, Шүлхий өвчний голомтот ажилласан 10 иргэний томилолт зардал зэрэгт 67.2 сая төгрөг,
- Аймгийн ЗДТГ-ын тогтвортой амьжиргаа төслийн өрөөний засварын урсгал зардал 5.8 сая төгрөг,
- Нөөц хөрөнгөд 40.0 сая төгрөгийг,
- Шугыла сэтгүүл гаргах зардалд 3.0 сая төгрөгийг,
- Сумуудын 2016 оны татварын буцаан олголтод 54.5 сая төгрөг.

Төсвийн хэлбэлзлийн тайлангаас харахад тухайн жилийн бараа үйлчилгээний бусад зардалд 180.9 сая төгрөг батлагдсан мэт харагдаж байгаа боловч 100.8 сая төгрөг нь Засаг даргын нөөц хөрөнгийн зардлын дансаар гүйгдэж тусгагдсан байна.

Аймгийн ИТХ-ын 2017 оны 6 дугаар сарын 28-ны 16 дугаар хуралдааны тогтоолын 6 дугаар хавсралтаар “Аймгийн 2016 оны орон нутгийн төсвийн үлдэгдлээс санхүүжүүлэх урсгал зардал”-ын жагсаалтад аймгийн ЗДТГ-ын бараа ажил үйлчилгээний зардалд нийтдээ 191.4 сая төгрөгийн төсөв баталж, дараах арга хэмжээнүүдэд зарцуулахаар төлөвлөсөн байна.Үүнд:

- 15 хүний эмчилгээний зардалд 52.4 сая төгрөг,
- “Заман” сонин, “Шугыла” сэтгүүл, Улсын начны орон сууцны дэмжлэг олгох зэрэг арга хэмжээнд 48.4 сая төгрөг,
- Шүүхийн шийдвэрээр олгох 9 хүний цалинд 41.9 сая төгрөг,
- Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэс, Улсын бүртгэлийн хэлтсийн гэрээт ажилтнууд болон Татварын хэлтсийн орон тооны бус байцаагчдын цалинд 32.7 сая төгрөг,
- Нэг удаагийн тэтгэмжид 6.0 сая төгрөг,
- Бусад арга хэмжээнд 10.0 сая төгрөг, нийт 191.4 сая төгрөг.

2.2. Давсан орлогыг төсвийн хууль тогтоомжийн дагуу зарцуулж, тайлагнасан байна.

Аймгийн ИТХ-ын тогтоолоор 2016, 2017 оны орон нутгийн орлогын давсан үлдэгдлээс хуваарилагдсан арга хэмжээнүүдийн санхүүжилтийг зориулалтаар нь зарцуулсан байна.

Аймгийн орон нутгийн орлогын давсан хэсгээс 2016 онд эмчилгээний зардалд 48.5 сая төгрөг, санхүүгийн дэмжлэгт 20.3 сая төгрөг, шүүхийн шийдвэрээр 67.0 сая төгрөг, Нийгмийн халамж үйлчилгээний хэлтэс, Статистикийн хэлтсийн гэрээт ажилтны хөлс, Жана өлке ОНӨАТҮГазрын ажилчдын цалин, Татварын хэлтсийн орон тооны бус байцаагч нарын цалинд нийт 35.7 сая төгрөг, Сумуудын татварын буцаан олголтод 54.5 сая төгрөг, Шугыла сэтгүүлийн зардалд 3.0 сая төгрөг, Тогтвортой амьжиргаа төслийн өрөөний урсгал засварт 5,0 сая төгрөг зарцуулж төлөвлөснөөс 45.0 сая төгрөгөөр бага гүйцэтгэлтэй гарсан байна.

Гэрээт ажилтнуудын цалингаас 5.0 сая төгрөг, нөөц хөрөнгөөс 40.0 сая төгрөг хэмнэсэн нь бодит хэмнэлт биш бөгөөд бодит хэмнэлт нь 11.2 сая төгрөг ба 33.8 сая төгрөг нь Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалт юм. Энэ нь зардлын ангиллын кодыг андуурч гүйлгэн зарцуулсантай холбоотой.

2017 оны төлөвлөгдсөн арга хэмжээнээс 2 хүний эмчилгээний зардал 1.5 сая төгрөг, Шүүхийн шийдвэрээр олгох 1 хүний цалин 3.5 сая төгрөг, Улсын бүртгэлийн хэлтсийн гэрээт ажилтнуудын олгогдоогүй цалин 3.1 сая төгрөг, бүгд 8.1 сая төгрөгийг хэмнэж төсөвт буцаан төвлөрүүлж, бусад арга хэмжээнд батлагдсан төсвийг хуваарийн дагуу зарцуулжээ.

Аудитын газраас 2015 онд аймгийн орон нутгийн орлогын давсан орлогын 2014 оны зарцуулалтанд хийсэн аудитаар 109.0 сая төгрөгийн зөрчил дутагдал илэрч зөрчлийг арилгуулахаар албан шаардлага өгөгдснийг арилгаж, давтан гараагүй байна.

2.3. Худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулсан байна.

2017 онд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар аймгийн ЗДТГ-ын барилгад 47.9 сая төгрөгийн их засвар хийж, Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 43.7 сая төгрөгийн авто тээврийн хэрэгсэл, 20.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил худалдан авсан байна.

ЗДТГ-ын байрны их засварын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах талаар www.tender.gov.mn сайт, Орон нутгийн өмчийн газрын www.tender.bo.gov.mn сайт, бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарласан байна.

Сонгон шалгаруулалтанд Көркем ХХК, Senturi-Link ХХК нар материалаа ирүүлсэн байна. Сонгон шалгаруулалтыг харьцуулалтын аргаар хийхээр урилга илгээж, тендерт оролцохоор материалаа ирүүлсэн “Көркем “ ХХК-ыг гүйцэтгэгчээр сонгож, гэрээ байгуулж, засварын ажлыг хийлгэж, орлого авч данс бүртгэлд тусгасан байна.

Автомашин, тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг шууд худалдан авалтаар гэрээ байгуулж авсан байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

1-р бүлэг.

Аймгийн ЗДТГазрын үйл ажиллагааны төсвийг хууль журамд заасны дагуу төлөвлөж, зарцуулжээ.

1. Тайлант оны үйл ажиллагааны батлагдсан төсөв үндэслэлтэй хийгдсэн байна.
2. Туслах үйл ажиллагаанаас орсон орлогыг төсвөөс гадуур зарцуулсан байна.
3. Байгууллагын үйл ажиллагааны бүтэц, орон тоог зохих журмаар баталж ажиллуулсан байна.
4. Дотоод хяналтыг зохих журмын дагуу хэрэгжүүлсэн байна.

2-р бүлэг

Засаг даргын нөөц хөрөнгийг хууль, журмын дагуу бүрдүүлж, зарцуулсан байна.

1. Засаг даргын нөөц хөрөнгийг төсвийн хууль тогтоомжийн дагуу төлөвлөж ажилласан байна.
2. Засаг даргын нөөц хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж, тайлагнасан байна.

3-р бүлэг.

Давсан орлогыг хууль, журмын дагуу бүрдүүлж, зарцуулсан байна.

1. Давсан орлогыг төсвийн хууль тогтоомжийн дагуу төлөвлөж, хуваарилсан байна.
2. Давсан орлогыг төсвийн хууль тогтоомжийн дагуу зарцуулж, тайлагнасан байна.
3. Худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулсан байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дор дурдсан албан тушаалтанд дараах зөвлөмжийг өгч байна.

Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга Х.Тилеген-д:

1. Сангийн яамнаас хянаж ирүүлсэн орон тооны хязгаарт багтаан бүтэц орон тоог жил бүр баталж, мөрдөж ажиллах. Зөвлөмжийн биелэлтийг 2019 оны 3 дугаар сарын 01-ны дотор ирүүлэх.

Байгууллагын санал

Аймгийн ЗДТГ-аас ирүүлсэн санал



Танай байгууллагаас 2016-2017 оны үйл ажиллагаа, Засаг даргын нөөц хөрөнгөө, давсан орлогын зарцуулалтанд хийсэн нийцлийн аудитын тайлантай танилцлаа. Албан шаардлагын дагуу гарсан санал байхгүй ба алдаа дутагдлыг арилгаж ажиллах болно.

ДАРГА  Х.ТИЛЕГЕН

00001297

ТАЙЛАНГ БАТАЛГААЖУУЛСАН:

Дарга, тэргүүлэх аудитор

М.Хуанган

ТАЙЛАНГ ХЯНАСАН:

Аудитын менежер

Х.Женисбек

ТАЙЛАНГ БЭЛТГЭСЭН :

Аудитор

Б.Үүрийнтуяа

Аудитор

Ж.Назгүл